

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

АУДИТЫН КОД: ӨМА-2026/14-15-ШТА-НА

ТӨРИЙН САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ОРОН НУТГИЙН
ОНЦЛОГТОЙ УЯЛДУУЛАН ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.



Даланзадгад хот 2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3
БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦООГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛЭХ ЭРХИЙГ ОРОН НУТАГТ ОЛГОХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	5
А.1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй нийтээр мөрдөх эрх зүйн актууд нь Төсвийн тухай хуулийн зохицуулалттай нийцэж байгаа ч зарим актыг шинэчлэх шаардлагатай байна.	5
А.2 ОРОН НУТГИЙН ЗЭРЭГЛЭЛТЭЙ ХОТЫН ТӨРИЙН САНГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ОРОН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	5
А.2.1 Төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг орон нутгийн онцлог, ажлын нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх шаардлага бий болсон байна.	5
А.2.3 Төрийн сангийн удирдлагын цахим систем нь ажлын хэрэгцээг хэвийн хангаж байгаа хэдий ч бусад төрийн байгууллагуудын программтай уялдуулах, ажлын ачааллыг хөнгөвчлөх, системийн хурд, ачааллыг нэмэгдүүлэх зэргээр хөгжүүлэлт, шинэчлэлт хийх нь зүйтэй байна.	9
БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	11
Б.1 ТӨСВИЙН САР, УЛИРЛЫН ХУВААРЬТ ҮНДЭСЛЭН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ОЛГООГҮЙ БАЙНА	11
Б.1.1 Санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд тогтмол, бүрэн олгоогүй байна.	11
Б.1.2 Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын эрхийг журмын дагуу баримт бичгийн шаардлага хангуулж олгоогүй байна.	12
Б.2 ТӨРИЙН САНГИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ БАТАЛГААЖИН ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.	13
Б.2.1 Төрийн сан нь нэгдсэн болон бүртгэлийн дансны төлбөр тооцоо, үлдэгдэл, баталгааг хугацаанд нь холбогдох системд бүртгэж, Монгол банк дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулан, илэрсэн зөрүүг тухай бүр залруулан ажилласан байна.	13
Б.2.2 Төрийн сангийн төлбөр тооцоо нь хууль, журмын дагуу хэрэгжиж байгаа боловч нэгдсэн хяналт сул байна.	13
Б.2.3 Бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулж, буцаасан байна.	13
Б.2.4 Тайлагналын тогтолцоо бүрдсэн боловч хугацаа, үнэн зөв байдалд анхаарах шаардлагатай.	14
Б.3. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДОТООД ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	15
Б.3.1 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хэрэгжүүлж төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж ажиллаагүй байна.	15
Б.3.2 Төрийн сангийн нэгжүүдэд эрсдэлийн үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	16
Б.3.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг сайжруулах хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.	16
ДҮГНЭЛТ	17
ЗӨВЛӨМЖ	18
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЯ	Сангийн яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем
ХОГ	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
БХГ	Барьцаа хөрөнгийн гүйцэтгэл
ЗХГ	Захиалагчийн хяналтын гүйцэтгэл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаа	6
Хүснэгт 2	Төрийн сангийн бүртгэлийн дансны төлбөр тооцооны мэдээлэл	7
Хүснэгт 3	Төрийн сангийн хянах, батлах хэрэглэгчдээс авсан төрийн сангийн цахим систем ашиглалтын судалгааны нэгтгэл	9
Хүснэгт 4	Төрийн сангийн төлбөр тооцоотой холбоотой санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил	13
Хүснэгт 5	Төрийн сангийн амжилтгүй болсон болон буцаасан гүйлгээний мэдээлэл	14

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад түүврийн арга ашиглан Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, Сангийн яам, Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд болон Төрийн сангийн удирдлагын цахим системийг /цаашид ТСУЦС гэх/ ашигладаг бусад төрийн байгууллагууд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2023-2025 оны төрийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, төрийн сангийн бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолттой нийцэж буй эсэх, хэрэгжүүлж буй дотоод хяналтын арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэхийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай;
- Төсвийн тогтвортой байдлын тухай;
- Засгийн газрын тусгай сангийн тухай;
- Шилэн дансны тухай;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам /ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоол/;
- Санхүүгийн алба байгуулах тухай /ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоол/
- Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар /2015 оны 90 дугаар тушаал/
- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт /2012 оны 294 дүгээр тушаал/;
- Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар /2016 оны 431 дүгээр тушаал/;
- “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал /2021 оны 190 дүгээр тушаал, 2025 оны 112 дугаар тушаал/;
- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар” /2014 оны 65 дугаар тушаал, 2024 оны 254 дүгээр тушаал/;
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар /2024 оны 256 дугаар тушаал/;
- Төрийн сангийн цахим системийн заавар /2024 оны 255 дугаар тушаал/;

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Одончимэг, аудитор Н.Хулан нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦООГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛЭХ ЭРХИЙГ ОРОН НУТАГТ ОЛГОХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1.2 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй нийтээр мөрдөх эрх зүйн актууд нь Төсвийн тухай хуулийн зохицуулалттай нийцэж байгаа ч зарим актыг шинэчлэх шаардлагатай байна.

1.1. Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2¹-т заасны дагуу Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан байна.

1.2. Төрийн сан нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1²-д заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн төрийн сангийн албан хаагчид Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

1.3. Энэ нь төрийн сангийн шинэчлэл, цахим системийн онцлог болон төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолттой бүрэн уялдаагүй бөгөөд зарим чиг үүрэг нь жишиг зааварт байхгүйг анхаарах нь зүйтэй.

1.4. Мөн уг зааврын 1.4.15³-д заасан төсвийн мэргэжилтнүүд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж тайланг улирал тутамд Сангийн яаманд хүргүүлэх гэсэн заалт хэрэгждэггүй байна.

1.5. Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 2.1.5⁴-д нягтлан бодогч ажилд авахад 2-оос доошгүй жил ажилласан байх шаардлага тавьдаг нь орон нутагт шинэ төгсөгч ажилд авах боломжийг хязгаарлаж, хүний нөөцийн зохиомол хомсдол үүсгэж байна.

1.6. Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн хооронд эрх шилжүүлэх зохицуулалт байхгүйгээс шалтгаалан ээлжийн амралтаараа ч гүйлгээг хянах, батлах шаардлага үүсдэг байна.

1.7. Орон нутагт төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй нийтээр мөрдөх эрх зүйн актууд нь Төсвийн тухай хуулийн зохицуулалттай нийцэж байна.

А.2 ОРОН НУТГИЙН ЗЭРЭГЛЭЛТЭЙ ХОТЫН ТӨРИЙН САНГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ОРОН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

А.2.1 Төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг орон нутгийн онцлог, ажлын нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх шаардлага бий болсон байна.

1.8. Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг 2002 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн сангийн тогтолцоонд шилжүүлж, Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн хэлтэс, сумын төрийн сангийн төлөөлөгч гэсэн бүтцээр хэрэгжүүлж ирсэн байна.

¹ 37.1.Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ

² 37.2 Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална

³ 1.4.15 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төсвийн орлогын давалт, тасралт, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны талаарх дэлгэрэнгүй тайланг улирал тутам гаргаж дараа сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлэх

⁴ 2.1.5 Шууд захирагч нарын ахлах нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оос доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх

1.9. Уг Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцэд Төрийн сангийн хэлтсийг бий болгон аймгийн Төрийн санд ерөнхий нягтлан бодогч болон тухайн төсөвтэй харилцагч 20 хүртэл төсөвт байгууллага тутамд нэг нягтлан бодогч байхаар тогтоосон байна.

1.10. Төрийн сангийн тогтолцоо нь Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1⁵-д заасны дагуу төв төрийн сан, аймгийн төрийн сан, сум, орон нутгийн зэрэглэлтэй хотын төрийн сан, төсвийн нягтлан бодогчоос тус тус бүрдэж байна.

1.11. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2⁶ дахь заалтаар аймаг, сумын төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын дэргэд байхаар хуульчилж өгсөн байна.

1.12. Засгийн газрын 2025 оны 37 дугаар "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/146 дугаар "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн тогтоох тухай" захирамжид Санхүү, төрийн сангийн хэлтсийг 9 орон тоотой байхаар баталсан байна.

1.13. Сумдад санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн тус бүр нэг орон тоогоор төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүснэгт № 1 Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаа

Төрийн сангийн чиг үүрэг харьяалагдаж байгаа нэгжийн нэр	Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэх албан тушаалын нэр	Батлагдсан орон тоо
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хэлтсийн дарга	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	1
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	1
Сумдын санхүүгийн алба	Санхүү албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	15
Сумдын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	15
Нийт дүн		39

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

1.14. Төрийн сангийн чиг үүргийг батлагдсан бүтэц орон тоо, чиг үүргийн дагуу үндсэн орон тоогоор бүрэн хэрэгжүүлж байна.

1.15. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3⁷-т заасны дагуу Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-т сумдад үйл ажиллагаа явуулж байгаа

⁵ 36.1 Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

⁶ 36.2 Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны Захирагчийн ажлын албаны дэргэд байна.

⁷ 36.3.Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.

төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан Санхүүгийн албыг байгуулсан байна.

1.16. Санхүүгийн албаны зохион байгуулалт чиг үүрэг, орон тооны жишиг нормативд Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж “2.2 ... ажлын ачааллыг харгалзан 2-3 данс хариуцсан 1 нягтлан бодогчтой байхаар орон тооны нормативыг тогтоох бөгөөд хариуцаж байгаа байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлнэ” гэжээ.

1.17. Аймаг, сумдын төрийн санд орон тоо нэмэгдүүлэх эрх зүйн акт байгаа хэдий ч энэ нь “Сумын Засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай, “Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолуудаар хязгаарлагдсан байна.

1.18. Дээрх нөхцөл байдлын улмаас аймгийн Засаг даргын 2025 оны А/303 дугаар “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, орон тооны загвар батлах тухай” захирамжийн хавсралтаар Нийтлэг үйлчилгээний газрын бүтэц орон тоонд баталсан эдийн засагчийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст төрийн сангийн гүйлгээ, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнээр ажиллуулж байгаа зөрчил илэрлээ.

1.19. Иймд Төрийн сангийн бүтэц зохион байгуулалтыг орон нутгийн онцлогтой уялдуулан шинэчлэх болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн орон тоог нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

1.20. Сүүлийн жилүүдэд /2021 онд 234,105.0 сая - 2025 оны 1,981,607.3 сая/ аймгийн төсвийн орлого 8.5 дахин нэмэгдсэн бөгөөд үүнийгээ дагаад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, төсвийн зарлагын ажил гүйлгээний тоо, давтамж өсөж төрийн сангийн үйл ажиллагааны ажлын ачаалал мөн 8.5 дахин нэмэгдсэн байна.

1.21. Төрийн сангийн гүйлгээний тоонд үндэслэн төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлын ачаалалд дүн шинжилгээ хийхэд аймгийн төрийн сан болон Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын төрийн сангийн төсвийн мэргэжилтний ачаалал, бусад сумын төрийн сантай харьцуулахад харьцангуй их байна.

Хүснэгт № 2 Төрийн сангийн бүртгэлийн дансны төлбөр тооцооны мэдээлэл /сая төгрөг/

№	Төрийн сангийн нэгжийн нэр	2023 оны гүйлгээний		2024 оны гүйлгээний		2025 оны гүйлгээний	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг	51406	928,606.2	54740	1,943,492.0	46974	1,672,162.0
2	Баяндалай	4287	4,449.1	3898	6,169.3	3580	7,128.1
3	Баян-Овоо	3453	5,263.8	3379	8,357.4	3196	7,847.5
4	Булган	3172	4,238.7	3512	15,125.0	3233	7,857.1
5	Гурвантэс	7102	42,797.2	7052	61,227.2	6772	76,954.9
6	Даланзадгад	20988	44,964.8	18626	70,188.4	16811	108,218.3
7	Мандал-Овоо	3172	6,394.7	3413	6,455.8	3135	6,603.4
8	Манлай	4128	6,361.9	4413	11,641.3	3938	13,016.4
9	Номгон	3785	5,795.8	4038	13,003.7	3948	9,794.2
10	Ноён	3475	9,405.4	3483	12,166.7	3084	9,390.6
11	Сэврэй	3721	7,537.6	3814	16,033.5	3612	13,225.9
12	Ханбогд	11149	196,922.7	11225	317,099.7	10948	406,848.7
13	Ханхонгор	4012	4,642.2	4141	10,614.8	4304	8,842.0

14	Хүрмэн	3547	3,810.4	3728	6,072.9	3257	6,032.2
15	Цогт-Овоо	4080	5,631.9	4624	10,032.2	4317	11,252.9
16	Цогтцэций	9327	62,644.7	8335	99,408.2	8073	127,177.4
	Дүн	140804	1,339,467.1	142421	2,607,088.1	129182	2,492,351.6

Эх сурвалж: Сангийн яам

1.22. Дээрх судалгаанаас харахад аймгийн төрийн сан, Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын төрийн санд хийсэн гүйлгээ нь нийт гүйлгээний 69.3 хувийг, мөнгөн дүнгийн 95.9 хувийг тус тус эзэлж байна.

1.23. Уул уурхай болон орон нутгийн бүтээн байгуулалт хөгжлийг даган хөдөлгөөнт болон суурин хүн амын тоо эрс нэмэгдэж, төрийн үйлчилгээ авах иргэн, аж ахуй нэгж, байгууллага, өрхийн тоо өссөн нь томоохон сумдын санхүүгийн алба, аймгийн төрийн сангийн чиг үүрэг, төрийн сангийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлага үүссэн байна.

1.24. Дээрх нөхцөл байдал болон төрийн байгууллагын уялдаагүй байдлаас үүссэн олон төрлийн мэдээ, тайлан, хяналт шалгалт, цалин хөлс, ажлын ачааллаас шалтгаалан санхүүгийн албанд ажиллах хүний нөөц тогтвор суурьшилтай ажилладаггүй, сумдад нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтний хомсдол үүссээр байна.

1.25. Иймд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар “Хот байгуулах тухай” тогтоолын дагуу орон нутгийн зэрэглэлтэй Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд хотууд болон аймгийн төрийн сангийн бүтэц зохион байгуулалт, орон тооны жишиг нормативыг орон нутгийн онцлогтой уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай байна.

А.2.2 Төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт нь бусад газар, хэлтсийн чиг үүрэгтэй давхцаагүй боловч ажлын ачааллыг нэмэгдүүлж, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих эрх, үүргийг хязгаарласан байна.

1.26. Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг заасан бол Сангийн сайдын 2015 оны 90 дугаар тушаалаар “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ыг баталсан байна.

1.27. Аудитын хүрээнд төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдаас “Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг үү” гэсэн судалгаа авахад сумдын санхүүгийн албаны дарга нар болон төрийн сангийн мэргэжилтнүүд 100 хувь “Нийцдэггүй” гэж хариулсан байна.

1.28. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 208 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч”, 3 дугаар хавсралтаар “Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн”-ийн албан тушаалын тодорхойлолтыг тус тус баталсан байна.

1.29. Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтын 2 дугаар зорилтын хүрээнд сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж тайлан баланс гаргах, сумын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгасан байна.

1.30. Санхүүгийн албаны дарга нь тусгай сангийн гүйлгээг өөрөө хийж, өөрийн гүйлгээг хянаж, батлах, санхүүгийн тайланг гаргаж нэгтгэх болон худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах, гэрээ байгуулах, гүйцэтгэлийн

санхүүжилт олгох, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх, гэрээ дүгнэх, ажил хүлээлцэх зэрэг бүхий ажилд оролцож байгаа нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцэхгүй байна гэж үзлээ.

1.31. Мөн ОНХС, ХХС зэрэг тусгай сангийн нягтлан бодох бүртгэл, ажил гүйлгээг холбогдох нягтлан бодогчид хариуцуулж, санхүүгийн албаны даргын хянан баталгаажуулах чиг үүргийг ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолттой уялдуулах нь зүйтэй.

1.32. Төсөв, төрийн сангийн мэргэжилтний хувьд сумын ЗДТГ-ын дотоод ажлуудыг хариуцуулж, албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу статистик мэдээллийг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах, тооллого мэдээлэл зохион байгуулах, нэгтгэл судалгааг долоо хоног, сар, улирал, жилээр гаргах ажлыг давхар хариуцаж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж төрийн сангийн төлбөр тооцооны хяналтыг сулруулах, үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна гэж үзжээ.

1.33. Аудитын явцад төрийн сангийн ажилтны үндсэн чиг үүрэгт үл хамаарах бусад ажил, судалгаа, статистикийн үүргийг салгаж, төрийн сангийн хяналт, төлбөр тооцооны үйл ажиллагааг төвлөрүүлэн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгөх саналыг гаргасан байна.

1.34. Төрийн сангийн албан хаагчдын ажилласан жилийн бүтцээс харахад 53.8 хувь нь тухайн албан тушаалдаа 5-аас дээш жил, 15.4 хувь нь 3-5 жил ажилласан байгаа нь төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлэгч хүний нөөц тогтвортой байгааг харуулж байна.

1.35. Үүнд Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3⁸-т заасан таван жил тутамд зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал, мөн 57 дугаар зүйлийн 57.17⁹-д заасан орон нутгийн нэмэгдэл олгосон нь тус тус нөлөөлсөн байна.

А.2.3 Төрийн сангийн удирдлагын цахим систем нь ажлын хэрэгцээг хэвийн хангаж байгаа хэдий ч бусад төрийн байгууллагуудын программтай уялдуулах, ажлын ачааллыг хөнгөвчлөх, системийн хурд, ачааллыг нэмэгдүүлэх зэргээр хөгжүүлэлт, шинэчлэлт хийх нь зүйтэй байна.

1.36. Төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал нь төрийн сангийн ажилтны ажлын хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор төрийн сангийн цахим системийн хэрэглэгч буюу хянах, батлах эрх бүхий нийт 33 хэрэглэгч хамрагдсан байна.

Хүснэгт№3 Төрийн сангийн хянах, батлах хэрэглэгчдээс авсан төрийн сангийн цахим систем ашиглалтын судалгааны нэгтгэл

№	Асуулт	Хариулт	Хувь
1	Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ	Бүрэн хангаж байна	63.6
		Хэвийн хангаж байна	36.4
		Хангалтгүй байна	0
2	Төрийн сангийн ажлыг гүйцэтгэхэд цахим системээс гадна цаасан суурьтай баримт үйлддэг үү	Тийм	75.7
		Үгүй	24.3
3	Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ	Интернэтийн саатал	30.3
		Программ тасалдал	57.6
		Цахилгаан	6.1
		Ойлгомжгүй байдал	6.1

⁸ 51.3.Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

⁹ 57.17.Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно.

4	Төрийн сангийн үйл ажиллагааг цахим систем ашиглан орон зай үл хамааран гүйцэтгэх боломжтой юу	Тийм	100
		Үгүй	
5	'Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байна уу	Тийм	100
		Үгүй	

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

1.37. Төрийн сангийн цахим систем нь ажлын хэрэгцээг хангаж байгаа бөгөөд аюулгүй байдал хангагдсан, орон зайнаас үл хамааран цахим системийг бүрэн ашиглах боломжтой гэж үзсэн байна.

1.38. Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 57.6 хувь нь программын тасалдал, 30.3 хувь нь интернэт тасалдал үүсдэг гэж хариулсан нь цахим системийн хурд, сүлжээний ачааллыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

1.39. Төрийн сангийн цахим системийн ашиглалтын хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах талаар систем хэрэглэгчдээс /239/ санал авсан бөгөөд дараах санал, хүсэлтүүд гарсан байна. Үүнд:

- Баримт бичгийн тохиргоо дээр өөр баримт андуурагдаж орсон тохиолдолд устдаггүй, зарим тохиолдолд баримт бичгийн тохиргоонд өөр аймгийн өөр албан хаагчийн мэдээлэл давхардаж орж ирдэг;
- Системийн ажиллагааг сайжруулж, ачаалал ихсэх үед (сарын эцэс, хагас, бүтэн жил) системийн хурдыг нэмэгдүүлэх;
- Дансны тохиргоо ойлгомжгүй гарын үсэг оруулахад үйлдэл зөв хэр нь орж ирэхгүйг ойлгодоггүй учир гарын авлагатай болох;
- Зарим тохиолдолд гүйлгээ батлах 1, 2 дугаар эрх алга болчихдог, төрийн санч, албаны дарга амарлаа гэхэд батлах эрх шилжүүлэх асуудал бэрхшээлтэй;
- Төрийн сангийн цахим системийн талаар сургалт зөвлөгөө маш их хэрэгтэй байна
- Шилэн данс руугаа бүрэн зөв татдаг баймаар байна;
- Хэрэглэгч нь хуулганаас зөвхөн өөрийнхөө хийсэн гүйлгээг хардаг болох;
- Нягтлангуудын олон программууд хоорондын уялдааг сайжруулах. Тухайлбал өмчийн программ, нийгмийн даатгалын зэрэг системтэй уялдуулах;
- Нэхэмжлэх үүсгэж хадгалахад тухайн нэхэмжлэхийн байршил харагддаггүй;
- Хөл дүн гардаггүй, гүйлгээнд хайлт хийхэд учир дутагдалтай;
- Цаг үеэ дагаж цахим системийг хурдтай, аюулгүй байдлыг хангаж өөрчлөлт шинэчлэлтийг хийж байх;
- Админ буюу хариуцсан мэргэжилтэнтэй холбогдоход хүндрэлтэй, асуудал гарахад эргээд хариулт өгдөг холбогдох утастай болох;
- Санхүүгийн ямар ч программд мэдээллийг хуулж дамжуулдаг болох;
- Төрийн сангийн цахим системээс бусад мэдээ тайланг бүрэн татдаг байх;
- Санхүүгийн программ руу гүйлгээ татахдаа эдийн засгийн ангиллыг татдаг болох, нэг бүрчлэн гараар бичдэгийг болиулах;
- Си ти эс санхүүгийн программ руу и хуулганаас орлого татдаг болох;
- Зарим зарлагын гүйлгээ санхүүгийн программ руу татахад харилцагчийн нэр солигдож орж ирдгийг болиулах;
- Төрийн албаны цалингийн системээс ХХОАТ болон нийгмийн даатгалын санд шилжүүлэг шууд хийгддэг байх;

- Гар утаснаас хандахад системийн ерөнхий болон бусад хэсэг дэх мэдээллийг үзэх боломжгүй хэмжээ, дэлгэцийн тохиргоо нь алдаатай байдгийг ямар ч төхөөрөмжөөс хандсан системийг бүрэн харах ашиглах боломжтой болгох;
- Бүх санхүүгийн программтай холбох юм уу аль эсвэл шууд тайлан бэлтгэгдэж бүх систем рүү татагддаг болбол ажил хөнгөвчлөхөөр байна;

1.40. Төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 өдрийн хугацаанд хүчинтэй байна гэж журамд заасан боловч цахим систем нь хуанлийн өдрийг оролцуулан 3 хоногоор тооцож гүйлгээг цуцалдаг байна.

1.41. Төрийн сангийн систем хэрэглэгчид цахим систем нь ажлын хэрэгцээг бүрэн хангаж байгаа хэдий ч программын хурд, аюулгүй байдлыг хангах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулж, өөрчлөлт, шинэчлэлт хийх, мэдээ тайлангууд цахимаас бүрэн, зөв татагдаж ажил хөнгөвчилдөг байхаар хөгжүүлэлт хийх нь чухал гэж үзсэн байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 ТӨСВИЙН САР, УЛИРЛЫН ХУВААРЬТ ҮНДЭСЛЭН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ОЛГООГҮЙ БАЙНА.

Б.1.1 Санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд тогтмол, бүрэн олгоогүй байна.

2.1. Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8¹⁰-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг олгож байна.

2.2. Санхүүжилтийн эрхийг холбогдох маягтын дагуу баталгаажуулан олгож байгаа ч зарим тохиолдолд батлагдсан төсвийн хуваарьтай бүрэн уялдуулахгүй, аймгийн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан аймгийн төрийн сангаас төсөв захирагч нар санхүүжилтийн эрхийг сард нэг ба түүнээс дээш олгосон байна.

2.3. Санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд тогтмол, бүрэн олгоогүй байна.

2.4. Санхүүжилтийн эрхийг журамд заасан хугацаанд олгохгүй байх нь төсвийн байгууллагуудын санхүүжилтийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн уялдааг сулруулж, зарим зардлыг хугацаанд нь санхүүжүүлэх боломжийг хязгаарлах, төлбөр тооцоо саатах, өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна.

¹⁰ 37.1.8.төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

Б.1.2 Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын эрхийг журмын дагуу баримт бичгийн шаардлага хангуулж олгоогүй байна.

2.5. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголтыг батлагдсан төсөв, төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн хугацаанд нь баримт бичгийн шаардлагад нийцүүлсэн эсэхийг түүвэрлэн үзэхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- Баяндалай, Ханхонгор, Цогтцэций сумдын төсвийн зарцуулалтын эрх олголтыг шалгахад батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг нээгээгүй, зарим эдийн засгийн ангиллаар зарцуулалтын эрхийг хэтрүүлэн олгож оны сүүлээр хасах дүнтэй 12,026,373,900 төгрөгийн тохируулга хийсэн,
- Төрийн сан нь төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох журмыг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох журмыг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Захиалагчийн хяналтын зардлын эрх олгох журмыг хэрэгжүүлээгүй, захиалагчийн хяналтын үлдэгдэл санхүүжилтийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажиллаагүй байна.

2.6. Зарцуулах эрхийг батлагдсан төсвөөс илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1¹¹, 37.1.8¹², Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.7.3¹³, 2.8.1¹⁴, 2.9.1¹⁵, 2.10.2¹⁶, 2.10.5¹⁷-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2.7. Иймд төсвийн сахилга бат алдагдах, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар захиран зарцуулах эрсдэл үүсгэсэн тул дээрх зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

¹¹ 37.1.1.төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;

¹² 37.1.8.төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

¹³ 2.7.3.Төсвийн хуваарь нь нэгдсэн дүнгээр батлагддаг төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг тухайн төрийн сангийн нэгж нь төсвийн батлагдсан хуваарьтайгаа сар бүр тулгаж, хянана;

¹⁴ 2.8.1.Төв төрийн сан болон аймаг, нийслэлийн төрийн сан нь тухайн шатны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжээс зохих журмын дагуу санхүүжилтийн эрх нээсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг энэ журмын 26 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан захиалагчийн дансанд шилжүүлж, зарцуулалтын эрхийг нээнэ;

¹⁵ 2.9.1.Төсвийн захирагч буюу захиалагч нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх нээлгэх хүсэлтийг энэ журмын 27 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан гэрээ, комиссын дүгнэлт, ашиглагч байгууллагын тодорхойлолтын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ;

¹⁶ 2.10.2.Төсвийн захирагч буюу захиалагч нь захиалагчийн хяналтын зардлын эрх нээлгэх хүсэлтийг энэ журмын 28 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан доорх материалын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ;

¹⁷ 2.10.5.Төсвийн захирагч нь захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа захиалагчийн хяналтын үлдэгдэл санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ

Б.2 ТӨРИЙН САНГИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ БАТАЛГААЖИН ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Б.2.1 Төрийн сан нь нэгдсэн болон бүртгэлийн дансны төлбөр тооцоо, үлдэгдэл, баталгааг хугацаанд нь холбогдох системд бүртгэж, Монгол банк дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулан, илэрсэн зөрүүг тухай бүр залруулан ажилласан байна.

Б.2.2 Төрийн сангийн төлбөр тооцоо нь хууль, журмын дагуу хэрэгжиж байгаа боловч нэгдсэн хяналт сул байна.

2.8. Төрийн сан нь төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээнд эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг, үндэслэх баримт бичиг, мэдээллийн бүрдэлд хяналт тавин ажиллаж байгаа боловч зөрчил байсаар байна.

2.9. Аймаг дахь төрийн аудитын байгууллагаас 2023-2025 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөр тооцоо, зарлагын гүйлгээг хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зөрчлүүд илэрсэн байна.

Хүснэгт № 4 Төрийн сангийн төлбөр тооцоотой холбоотой санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

№	Зөрчлийн утга	2023 он		2024 он		2025 он	
		Тоо хэмжээ	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Анхан шатны баримтгүй	2	2.802.9	1	2.1	1	3.6
2	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	26	185.2	20	380.6	8	124.1
3	Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн	39	230.7	39	314.1	20	79.9
	Дүн	67	3,218.8	60	696.8	20	207.6

Эх сурвалж: Зөрчлийн нэгтгэл судалгаа

2.10. Дээрх судалгаанаас харахад аудитын байгууллагын зөвлөмжийн мөрөөр төрийн сангийн төлбөр тооцоотой холбоотой анхан шатны баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн зөрчлийн тоо дүн буурсан байна.

Б.2.3 Бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулж, буцаасан байна.

2.11. Төрийн сан нь төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансаар дамжин хийгдэж буй тодорхойгүй орлого, буцаалтын гүйлгээг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохицуулж, дансны хөдөлгөөний ил тод байдал, үнэн зөв байдлыг ханган ажилласан байна.

2.12. Тодруулбал, тодорхойгүй орлогыг түр хугацаанд холбогдох дансанд төвлөрүүлэн бүртгэж, тухайн орлогын эх үүсвэр, зориулалтыг тогтоох хүртэл тусгаарлан байршуулж улмаар гүйлгээний холбогдох баримт бичиг, мэдээллийг үндэслэн шалгаж

баталгаажуулсны дараа тухайн орлогыг зөв эзэмшигчид шилжүүлэх, эсхүл холбогдох төсвийн орлогод ангилан бүртгэх замаар гүйлгээг залруулан буцаадаг байна.

Хүснэгт № 5 Төрийн сангийн амжилтгүй болсон болон буцаасан гүйлгээний мэдээлэл /сая төгрөг/

Гүйлгээний төлөв	2023 оны гүйлгээний		2024 оны гүйлгээний		2025 оны гүйлгээний	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Амжилтгүй	2440	5,669.1	2040	23,225.3	2319	13,452.9
Буцаасан	4296	8,312.3	2898	11,240.1	1911	12,730.2
Нийт дүн	6736	13,981.4	4938	34,465.4	4230	26,183.1

Эх сурвалж: Сангийн яам

2.13. Буцаасан болон амжилтгүй болсон гүйлгээний тоо, дүн буурсан үзүүлэлттэй байна.

2.14. Дээрх гүйлгээнүүд нь төсвийн багц хүрэлцэхгүй, үнийн дүн, нэр зөрүүтэй, хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу, 2025 оны хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаартай албан даалгаврын дагуу тус ангилал нь гүйлгээ үүсгэх боломжгүй нөхцөл үүссэн зэрэг шалтгаанаар гүйлгээ буцаагдсан байна.

2.15. Буцаалтын гүйлгээг хийхдээ анхан шатны баримт, хүсэлт, тайлбар мэдээлэлд тулгуурлан тухайн гүйлгээний үндэслэл, зөвшөөрлийг хянан баталгаажуулж, холбогдох бүртгэлд тухай бүр тусган хэрэгжүүлсэн байна.

Б.2.4 Тайлагналын тогтолцоо бүрдсэн боловч хугацаа, үнэн зөв байдалд анхаарах шаардлагатай.

2.16. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн боловсруулж, тайлагнаж байгаа нь тайлагналын үндсэн тогтолцоо бүрдсэн, үйл ажиллагаа тодорхой түвшинд хэвийн явагдаж байгааг харуулж байна.

2.17. Гэсэн хэдий ч тайлагналын хэрэгжилтийн явцад зарим төрлийн тайлан, мэдээллийг журамд заасан шаардлагын дагуу бүрэн бэлтгэж, хугацаанд нь ирүүлэхгүй байгаа зөрчил байсаар байна.

2.18. Тухайлбал, төсвийн захирагч буюу захиалагчаас төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарцуулалт, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зарцуулалт, захиалагчийн хяналтын зарцуулалтын мэдээг тус тус Маягт-ХОГ, Маягт-БХГ, Маягт ЗХГ-аар бэлтгэн ирүүлээгүй байна.

2.19. Дээрх зөрчил нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.8.6¹⁸, 2.9.4¹⁹, 2.10.4²⁰-д заасантай нийцэхгүй байна.

¹⁸ 2.8.6. Төсвийн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарцуулалтын мэдээг энэ журмын 29 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төв төрийн сан болон аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ.

¹⁹ 2.9.4. Төсвийн захирагч буюу захиалагч нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зарцуулалтын мэдээг энэ журмын 30 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төв төрийн сан болон аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ.

²⁰ 2.10.4. Төсвийн захирагч буюу захиалагч нь захиалагчийн хяналтын зарцуулалтын мэдээг энэ журмын 31 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төв төрийн сан болон аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ;

2.20. Холбогдох тайлан, мэдээллийг хугацаанд нь ирүүлээгүйгээс шалтгаалан төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулах, байгууллага хоорондын тооцоо, өглөг, авлагын тулгалтыг үнэн зөв хийх, зөрүүг цаг тухайд нь илрүүлж залруулахад хүндрэл учруулах эрсдэлтэй байна.

2.21. Иймд төсвийн захирагч, захиалагчийн түвшинд тайлагналын сахилга батыг сайжруулах, тайлан, мэдээний бүрдэл, чанар, хугацаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, холбогдох журам, зааврын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

Б.3. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДОТООД ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.3.1 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хэрэгжүүлж төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж ажиллаагүй байна.

2.22. Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 36.6²¹-д заасны дагуу хэрэгжүүлэхдээ Сангийн сайдын 2014 оны 65, 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

2.23. Аймгийн Засаг даргын 2023 оны А/451 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу 9 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэн зөвлөмж өгч ажилласан боловч зөвлөмжийн биелэлтийг тооцоогүй байна.

2.24. Аймгийн Засаг даргын 2024 оны А/416, 2025 оны А/119 дугаар захирамжаар сумдын санхүүгийн албаны 2024, 2025 оны төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг батлуулсан боловч сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод хяналт хийгдээгүй байна.

2.25. Төрийн сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг бууруулахад чиглэсэн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж ажиллаа.

2.26. Аймгийн төрийн сангийн нэгжүүдэд дотоод хяналт хэрэгжүүлсэн тайлан, эрсдэлийн үнэлгээний хамт Сангийн яамны төрийн сангийн газарт жил бүрийн 1 сард хүргүүлж ажилласан байна.

2.27. Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төрийн сангийн үйл ажиллагааны журам, цахим систем, шинэчилсэн программуудын талаар төрийн сангийн мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч, өдөр тутмын хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

2.28. Аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, өдөр тутмын хяналтыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлсэн боловч төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлээгүй

²¹ Төв төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

байгаа нь төрийн сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг бууруулаагүй, төлбөр тооцооны хяналт сулрах эрсдэлийг үүсгэсэн байна.

Б.3.2 Төрийн сангийн нэгжүүдэд эрсдэлийн үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

2.29. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын дагуу тодорхойлж ажилласан байна.

2.30. Өмнөговь аймгийн төрийн сангийн нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг ангиллын дагуу үнэлж нэгтгэн эрсдэлийн түвшнийг тооцсон ч ач холбогдлын зэргийг тодорхойлж дунд, их эрсдэлийг бууруулах болон эрсдэлийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

2.31. Эрсдэлд суурилсан хяналтын арга барил бүрэн нэвтрээгүй байгаа нь эрсдэлийн үнэлгээ нь зөвхөн баримтжуулалтын түвшинд хэрэгжиж, эрсдэлийг бууруулах бодит арга хэмжээ, түүний хэрэгжилт, хяналт, тайлагнал хангалтгүй байгаа нь эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг бууруулж байна.

Б.3.3 Төрийн сангийн үйл ажиллагаанд зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг сайжруулах хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

2.32. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д заасны дагуу "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг ойлгоно.

2.33. Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2023-2025 онд аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.34. Мөн төв төрийн сангаас аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.35. Төрийн аудитын байгууллагаас 2018 онд нэгдсэн удирдамжаар “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт аудит гүйцэтгэж аудитын тайлан зөвлөмжийг хүргүүлсэн байна.

2.36. Төрийн аудитын байгууллагаас жил бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгч ажиллаж байгаа бөгөөд аудитаар төсвийн зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн, төрийн сангийн төлбөр тооцоо, тайлагналтай холбоотой зөрчлүүдэд холбогдох арга хэмжээг авч ажиллах, зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажилласан ч зөрчил дутагдал байсаар байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй нийтээр мөрдөх эрх зүйн актууд нь Төсвийн тухай хуулийн зохицуулалттай нийцэж байгаа ч зарим актыг шинэчлэх шаардлагатай байна.
- Төрийн сангийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг орон нутгийн онцлог, ажлын нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх шаардлага бий болсон байна.
- Аймгийн төрийн сан, Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын төрийн санд хийсэн гүйлгээ нь нийт гүйлгээний 69.3 хувийг, мөнгөн дүнгийн 95.9 хувийг тус тус эзэлж байна.
- Төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт нь бусад газар, хэлтсийн чиг үүрэгтэй давхцаагүй боловч ажлын ачааллыг нэмэгдүүлж, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих эрх, үүргийг хязгаарласан байна.
- Төрийн сангийн удирдлагын цахим систем нь ажлын хэрэгцээг хэвийн хангаж байгаа хэдий ч бусад төрийн байгууллагуудын программтай уялдуулах, ажлын ачааллыг хөнгөвчлөх, системийн хурд, ачааллыг нэмэгдүүлэх зэргээр хөгжүүлэлт, шинэчлэлт хийх нь зүйтэй байна.
- Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтын эрхийг журмын дагуу баримт бичгийн шаардлага хангуулж олгоогүй байна.
- Санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хугацаанд тогтмол, бүрэн олгоогүй байна.
- Төсвийн санхүүжилт, зарцуулалтын эрхийг журамд заасан хугацаанд олгохгүй байх нь төсвийн байгууллагуудын санхүүжилтийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн уялдааг сулруулж, зарим зардлыг хугацаанд нь санхүүжүүлэх боломжийг хязгаарлах, төлбөр тооцоо саатах, өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна.
- Төрийн сангийн төлбөр тооцоо нь хууль, журмын дагуу хэрэгжиж байгаа боловч нэгдсэн хяналт сул байна.
- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хэрэгжүүлж төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж ажиллаагүй байна.
- Төрийн сангийн нэгжүүдэд эрсдэлийн үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- Төрийн сангийн үйл ажиллагаанд зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг сайжруулах хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, зохион байгуулалтыг орон нутгийн онцлог, ажлын нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх, холбогдох арга хэмжээг авч ажиллах

Санхүү, төрийн сангийн хэлтэст:

- Төрийн сангийн нэгжүүдэд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт тооцож ажиллах;
- Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж, хавсралт маягтуудыг бүрэн хөтлөх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/21

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-н 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор (С.Одончимэг)-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг аудитор (Н.Хулан)-т даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.

5. Аудитын тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан ажлын болон нотлох баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Н.Хулан)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР

4626010036

**Монгол улс, Өмнөговь аймаг, Даланзадгад сум 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 3 давхар
Утас: +976 70533559, +976 70533552
И –мэйл: umnugovi@audit.gov.mn,
Вебсайт: www.audit.mn**